



ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН ТЭРГҮҮЛЭГЧДИЙН  
ТОГТООЛ

2019 оны 06 сарын 29 өдөр

Дугаар 61

Мандалговь

Автомашинд үнэлгээ тогтоож,  
худалдах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2 дахь хэсгийн 77.2.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2018 оны 77 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн өмчит эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 6 дугаар бүлгийн 6.2 дахь хэсгийн 6.2.1, 6.4 дахь хэсгийн 6.4.1 дэх заалтыг тус тус үндэслэн аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдээс ТОГТООХ НЬ:

1. Баянжаргалан сумын Засаг даргын тамгын газрын үндсэн хөрөнгөнд бүртгэлтэй 17,000,000 /арван долоон сая/ төгрөгийн балансын үнэтэй, 1,833,333 /нэг сая найман зуун гучин гурван мянга гурван зуун гучин гурван төгрөг/ мөнгөний үлдэгдэл өртөгтэй 49-21 ДУА улсын дугаартай Форестер маркын автомашины худалдах доод үнийг 3,500,000 /гурван сая таван зуун мянга/ төгрөгөөр тогтоон дуудлага худалдаанд оруулахыг зөвшөөрсүгэй.

2. Эд хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу худалдаж, хөрөнгө худалдсанаас орох орлогыг Төрийн сангийн хөрөнгө борлуулсны орлогын 100080000962 тоот дансанд бүрэн төвлөрүүлэхийг Орон нутгийн өмчийн газар /С.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

3. Эд хөрөнгийг худалдсаны дараа холбогдох хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэхийг Баянжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын даргын түр орлон гүйцэтгэгч Э.Сувдад даалгасугай.

4. Энэхүү тогтоолын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг дарга /О.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

ДАРГА  С.СҮХБААТАР

480219146